

**МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГ БА А.АЮУШИЙН
ТЭМЦЭЛ ХӨДӨЛГӨӨН**

Харнууд З.Лонжид

Өгүүллийн товч: Халх Монголын баруун хязгаарын нэрт тэмцэгч А.Аюушийн тухай судалгаанд шууд холбогдох зарим зүйлийг энэхүү өгүүлэлд авч үзлээ.

Түлхүүр үг: Цэцэг нуур, Ховдын сайд Соном, Гонгоржав, Нацагдорж

Нэг. Сурвалж хэрэглэгдэхүүний тойм

Ард Аюушийн тэмцэл хөдөлгөөнтэй холбогдох сурвалж нилээд ховор бөгөөд одоогоор Үнэсний төв архив болон ШУА-ийн түүхийн хүрээлэнгийн Түүхийн баримтын санд хэд хэдэн баримт байгаа нь бүгд хуулбар юм. Эдгээрээс хоёрыг нь судлаачид 1959, 1968, 1982 онд хэвлүүлж судалгааны эргэлтэнд оруулжээ. А.Аюуш энх тунх байхдаа өөрийн хүү Цэвэг, үеэл дүү Халтар, хүр дүү Мөнхөө нартаа хэлж бичүүлсэн дуртгалыг 1940-өөд онд Ховд аймгийн Намын Хороо Шинжлэх ухааны хүрээлэнд шилжүүлэн өгснийг 1959 онд тус хүрээлэнгийн Түүх судлах газар тусгай товхимол болгон хэвлүүлжээ. Үүний дараа 1968 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс "Ардын заргын бичиг" хэмээх баримт бичгийн эмхтгэлд 1917 оны 11 дүгээр сарын 25-нд Дархан засгийн хошууны тугагч Чогсомжав, тайж Соном, Гонгоржав, Гомбожав, харц Аюуш, Баатар нарын зурган хүн Монгол Улсын Шүүх Яаманд бичсэн 44 зүйл бүхий заргыг нийтэлсэн байна. Аюушийн тэмцэл хөдөлгөөнтэй шууд холбогдох бас нэгэн баримтыг 1982 онд судлаач А.Сир, Г.Пүрэвээ нар 1900-1914 оны үеийн Монголын түүхэнд холбогдох баримтуудыг эмхтгэлд хэвлэсэн байна.

Үүнээс гадна 1930 онд Аюуш МАХН-ын VIII их хуралд төлөөлөгчөөр сонгогдон оролцоход нь ЗХУ-аас Монголд сууж байсан бүрэн эрхт төлөөлөгчийн газрын зарим ажилтан түүтэй уулзаж дуртгалыг нь бичиж авсан юм гэнэлээ хэмээх аман мэдээ байдаг боловч эдүгэе чухам хаана буй нь тодорхойгүй.

Эдгээс сурвалжаас гадна Ховд аймгийн Улсын архивын эрхлэгч Мул гэдэг хүн 1987 онд З.Лонжид надад ярьснаар бол тус архивт Аюуштай холбогдох хэд хэдэн зүйл байдгийн ихэнх нь Цэцэг нуурын дугуйланд оролцож явсан хүмүүсийн дуртгал бололтой юм билээ. Бүх тэдгээр нь судалгааны эргэлтэд орсон эсэх нь тодорхойгүй. Энэ тухай Ховдын намын архивын эрхлэгч Агваандорж абугайгаас хожим лавлахад ер мэдэхгүй, өөрөөс чинь л анх сонсож байна гэсэн. Мөн эрдэмтэн багш Х.Пэрлээ 1960-аад онд Аюушийн хучин хөшөөг Ховд хотоос Цэцэг сумын төвд шилжүүлэхэд ШУА-ийн томилолтоор очиж тус сумын хэд хэдэн хүнтэй уулзаж, Аюушийн тухай яриулан тэмдэглэж бичсэн хоёр, гурван жижиг дэвтэр ШУА-ийн түүхийн хүрээлэнд байгаа болов уу.

Миний бодоход цаашид Аюушийн тухай судалгааг тусгайлан анхаарч юуны өмнө энэ чиглэлийн сурвалж баримтыг эмхэлж цэгцлэхээс эхлэх нь чухал болжээ.

Хоёр. Судалсан байдлын тойм

XX зуны Монголын түүхэнд нэрээ мөнхөлсөн ард Аюушийн хөдөлгөөний тухай судалгаа бид манай эх түүхийн шинжилгээнд зийлшгүй авч үзэх ёстой асуудал мөн билээ. Тиймээс ч түүхчдийн бүтээлд энэ талаар олонтаа хөндсөн төдийгүй гадаадын

зарим улсын түүхийн нэвтэрхий тольд түүний тухай тэмдэглэсэн байна. (СИЭ-1961.1023) Жич: Зохиолч Цэдэнжав, Б.З.Шумяцкий, А.Каллиников нарын зарим бүтээлд А.Аюушийн тухай товч дурдсан байдаг бололтой. Гэвч би эдгээрийг олж үзээгүйдээ хүлцэл өчиж байна. Миний гүймэг судалгаагаар бол манай түүхчдээс хамгийн анх авч үзсэн хүн бол нэрт түүхч Ш.Нацагдорж багш юм. Тэрбээр 1941 онд *“Халх дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ба феодалыг эсэргүүцсэн хөдөлгөөнүүд”* хэмээх зохиолдоо Засагтхан аймгийн Дархан засгийн хошуу нь 238 өрхтэй бөгөөд хятад худалдаачдад төлөх ёстой олон жилийн хур өр нь 240 мянган лан хүрч нэг өрхөд 1008 лан ногдох болсонд тус хошууныхан бараг бүгдээрээ уул өрийг төлөх боломжгүй учир эсэргүүцэж эхэлснийг Цэцэг нуур сумын багийн дарга ард Аюуш удирдаж өрийн мөнгөнөөс гадна өртөөний албыг ч хаахгүй гэдгээ засаг ноёнд уламжилсан тухай Ш.Нацагдорж багш өгүүлж улмаар уул хөдөлгөөний үндсэн шаардлагыг зургаан зүйлд хувааж тодорхойлсон бөгөөд тэдгээр нь 1. Өртөөний албыг хөнгөлөх, 2. Ноёны албыг бага болгох, 3. Феодал ноёдын хэтэрхий эрх ямбыг устгах, 4. Хятад худалдаачдын өрөөс чөлөөлөх, 5. Ноёдод биеэр алба хаахыг зогсоох, 6. Орон нутагт ард олны өөрийн захиргааг байгуулах (Нацагдорж. 1941.16) хэмээн ангилжээ. Мөн ард Аюушийн удирдсан Цэцэг нуурын дугуйлангийн нөлөөгөөр 1906 оноос эхлэн Ёст засаг, Сартуул Сэцэн засаг, Жонон засгийн хошуудад ард олны эсэргүүцэл тэмцэл өрнөж, Цэцэг нуурынхны адил шаардлага тавих болжээ. Иймд мөн оны эцсээр Засагт хан аймгийн ноёд дангаараа болон Улиастайн жанжин Ховдын сайд лугаа хүчин хамтарч дарахаар удаа дараа оролдсон боловч чадаагүй учир *“1906 оны аравдугаар сард Манж Хятадын захиргаанаас хятад монгол нийлсэн зэвсэг бүхий зуун морин цэргийг тусгайлан гаргаж явуулснаар сая Цэцэг нуурын дугуйланг зэвсгийн хүчээр дарсан баймой”* (Нацагдорж 1941.19)- гэж На багш энэ номдоо бичсэнээс үзвэл ард Аюушийн хөдөлгөөнийг дарахын тулд Манжийн төр тусгай цэрэг монголд ирүүлсэн буюу магадгүй Улиастайн манж жанжны газраас цэрэг гаргаж зэвсгийн хүчээр дарсан бололтой. Үүнээс 13 жилийн дараа Монгол-Зөвлөлтийн түүхчдийн хамтран туурвисан *“БНМАУ-ын түүх”* нэг боть зохиолд *“ард түмний ангийн тэмцлийн хамгийн хурцын нэг нь Засагтхан аймгийн Манибазар ноёны хошуунд гарсан Аюушийн хөдөлгөөн гэдэг ардын тэмцэл юм”* (БНМАУ-ын 1955.266) гэсэн ганц өгүүлбэр байгаа нь тус зохиолын хэмжээнд арга буюу захируулсных бололтой. 1959 онд Аюушийн төрсний 100 жилийн ойд зориулж судлаач Г.Цэрэндорж абугай Аюушийн тэмцэл хөдөлгөөний тухай бэсрэг товхиц (8 нүүр) хэвлүүлсэн нь энэ сэдвээр олны хүртээл болсон анхны тусгай зохиол байлаа. Энэ товхицын эхний хэсэгт Аюушийн намтрыг товчлон өгүүлж түүний эцэг Алдаржав нь хөрөнгө ядуу мал ан гөрөөгөөр амь зуудаг байсан ба Аюуш 18-тайдаа өрх тусгаарлаж харьяат хошууны засаг ноён Юндэндоржийн хиагаар томилогдож, тэр хошуу нь Захчинтай нутаг булаацалдан маргахдаа Аюушийг сул зөвлөгчөөр дагуулан явж заргаа авч байсныг тэр хошууны албат ард Тэгшбаярын дуртгал ярианд тулгуурлан тэмдэглэжээ. Юндэндоржийн хоёрдугаар хүү Манибазар 1900 онд эцгийнхээ ор суурийг залгамжилсан ба тэрбээр харьяат ард иргэддээ хатуу ширүүн ханддаг, хошуу хотлоо хэтэрхий харгислан дарладаг, харийн шунахай худалдаачидтай дотно харилцаатай бөгөөд нэг түм шахам хонь, 3000 орчим адуу, мянга гаруй тэмээтэй их олон үхэртэй байсан хэмээн дурдсан боловч чухам ямар эх сурвалжаас авснаа заасангүй. Гэтэл энэ тоог зарим мэдээтэй харьцуулахад нилээд зөрүүтэй байгаа тул тус хошууны 1918 оны мал тооллогын хүснэгтийг уншигч абугай Танаа толилуулах нь илүүц бус гэж үзлээ.

Дархан засгийн хошууны малын тоо 1918 он

Өмчлөгч эзэд	Малын тоо толгой (төрлөөр)				
	Тэмээ	Адуу	Үхэр	Бог	Бүгд дүн
1. Хошууны ард	332	692	2300	22191	25515
2. Ноёд, лам нар	138	1236	171	3773	5318
3. Жас	33	266	385	6359	7043
Дүн	503	2194	2856	32323	37876

Сурвалж: Майский И.-2001. Хавсралтын 9, 21, 26, 59, 63, 67, 71 дэх талд буй мэдээнүүдийг нэгтгэж авав.

Энэхүү хүснэгтийн тоог Г.Цэрэндорж абугайн бичсэнтэй харьцуулахад тун их зөрөөтэй байгаа нь чухам ямар учиртайг цаашид нягтлууштай.

Г.Цэрэндорж абугай товхицынхоо дунд хэсэгт нь Аюушийн тэмцэл анх 1903 онд эхлэхдээ засаг ноён нь дотно сүлбээтэй харь худалдаачидтай эвсэж, ард олныг шулан мөлжиж бйгааг эрс эсэргүүцэж заргын бичиг зохиож өөрөө бусад 11 хүний хамт Засагт хан аймгийн чуулганы газар явуулахаар бэлтгэж байсныг Манибазар мэдэж тэднийг баривчлан авахад Аюуштай хамтран тэмцэж байсан зарим тайж нар няцаж засагтайгаа тэмцэхгүй гэснээр тэднийг тус бүр таван малаар торгосноор уул тэмцэл амжилтгүй болсон гэжээ.

Гэвч Аюушийн удирдсан хөдөлгөөний нөлөөгөөр бусад хошуудад үүссэн тэмцэл улам өрнөхөөр Цэцэг нуурын босогчид тэмцлээ дахин сэргээсэн байна.

Засагт хан аймгийн Сэцэн засгийн хошуунд байнга худалдаа эрхэлдэг хятад иргэд Монголынүндэсний эрх чөлөөний хувьсгал эхэлж Богдыг улсын эзэн хаанаар өргөмжилж хятадын мөлжимтгийн худалдаачдад тун таагүй хандаж байгааг сонсоод тэвдэн сандарч Ховд хязгараар хил нэвтрэхийг зорьж гараад 1911 оны нэгдүгээр сарын 12-нд мөн аймгийн Дархан засгийн хошууны нутаг Цэцэг нуурт суурин сууж Буянтын пүүсний салбарыг удирдаж байсан орлио хэмээх хочтой хятад Түмэнжаргалын ирж дээрх байдлын тухай сонсгосон байна. Түмэнжаргал ч мөн айж хамгийн үнэтэй эд бараагаа шилж, хориод тэмээнд ачиж Банди, Төмөр зэрэг зургаан хүнийг хөлслөн пүүснийхээ адууг туулган явуулаад нилээд эд бараа мал эзэнгүй орхиж Захчины нутаг руу дүрвэн оджээ.

Түмэнжаргалыг явсны дараа тэр нутгийн Төмөр зэрэг хэдэн хүн тэр даруйд нь яаран сайдран засаг ноёндоо очиж мэдэгдсэн байна. Засаг Маньбазар үүнийг сонсмогцоо Аюур хэмээгчийг томилон мордуулж, Цэцэг нуурт нутаглаж буй туслагч Чогсомжав, занги Жамъян нарт тушааж тэрхүү эзэнгүй эд бараа малыг чанд хамгаалж байхыг далгажээ. Гэтэл Аюурыг очихоос өмнө мөнөөх Чогсомжав, тайж Соном зэрэг эр эм 200 гаруй хүн дээрх эд бараа малыг аль хэдийнээ хуваан авцгаасан байжээ. Үүнээс эхлэн нэгэн хэрэг үүсч засаг Маньбазар юуны өмнө орлио Түмэнжаргалыг эрж олуулан тамгын газартаа дуудаж уулзан түүний дүрвэн зайлсны учрыг мэдэж, улмаар пүүсийн эд мал хуваах авсан буруутан болох туслагч Чогсомжав зэрэг 30 гаруй тайж ардыг зарлан авчирч байцааж нилээд зүйлийг тодруулжээ. Тухайлбал Түмэнжаргалын адууг Захчины нутагт хүрэхээр зарагдсан Төмөр зэрэг зургаан хүн явах зам зуураа хориод морь авсан ба буцаж мөнөөх сууринд ирэхэд нь Чогсомжав түүний хүү Агваан зэрэг олон хүн зүг

зүгээс ирцгээж, тэндээ хоноод маргааш нь тус пүүсийн орхисон бүх монгол гэрийг *"тамгагүй болгон эвдэлж эд малыг"* хуваан авцгаасан гэж мэдүүлжээ.

Ийнхүү өчиг авсныхаа дараа Маньбазар лам Агваан, ард Аюуш, Дансүрэн, Чойдон, Лэгцэг, Баатар зэрэг зургаан хүнийг баривчилж гавлаж гинжлэн дарга, хуяг 10 хүнийг томилон манаж цагдуулан уул хэргийг цаашид нягтлахаар бэлтгэжээ. Гэтэл тэр шөнө нь 30 илүү хүн тэрхүү зургаан хүнийг *"түрхрэн өмгөөлж өндөр дуугаар хашгаралдан сүр гаргаж бид нар хүн алах боловч айхгүй, бусдад хорлогдох боловч эмээхгүй бас бид нар оргож зайлахгүй хэмээн олноор эрэмшиж бүл зааж, тэдний хадгалсан дарга хуяг 10 хүнийг тэмээ хом мод, гэрийн униар зэрэг зэрэг занчин хуяг Дамдинг үхширтэл занчин"* (Монголын 1982. 107-108) мөнөөх зургаан хүнийг булаан авч явжээ. Үүнийхээ дараа тэдгээр босогчид Гүнтийн (Хөндийн?) ам хэмээх газар очиж туслагч Чогсомын хамт нэг зуугаад хүн эр цэрэг мэт болж сууцгаасан байна. Байдал нэгэнт ийм эгзэгтэй болсон учир засаг Маньбазар Засагт хан аймгийн чуулган даргын газар бичиглэн мэдэгдэж, улмаар Улиастайн сайдад уламжилсан ажээ.

Сурвалжийн энэхүү мэдээг судлаач Г.Цэрэндорж бусад мэдээгээр тодруулж Түмэнжаргал хэмээх хятадын орхисон зүйлийг тэр хавьд нь байсан ард тайж 165 хүн ард Аюушийн удирдлагаар хуваан авсан боловч тэднийг засаг ноёны шийдвэрээр баривчлан хар гэрт хорьж мөн л харгис эрүү шүүлт тулгаж тайж нарыг нь хэдэн зуун лангаар ардуудыг нь 50-60 лан мөнгөөр торгож, хоол ундгүй шахам байлгасанд нутгийнх нь ардууд мод чулуугаар зэвсэглэн босож бүх хоригдогчдыг шоронгоос суллахад тэд Хөндийн ам гэдэг газарт очиж бүгэн сууж засаг ноёныхоо эрх ямба алдар тушаалыг бууруулах (Цэрэндорж-1959.6) зорилго тавьж 44 зүйл зарга бичиж Аюуш тэргүүтэй 6 хүнийг төлөөлөгчөөр сонгож, Засагт хан аймгийн чуулган даргын газар очуулсан боловч эрх мэдэлтнүүд уг хэргийг шийдвэрлэхгүй удаашруулсаар сарниулахыг хичээж байжээ.

Иймд Манибазар ноёны хүссэнээр баруун хязгаарын цэргийн сайд төлөөний түшмэл 1913 оны хавар Аюуш нарын хэргийг Гурван цэнхэрийн аманд харгис хэрцгийгээр эрүүдэн шүүж хятад худалдаачны барааг дээрэмдсэн, хууль ёсны эзэн ноёныхоо эсрэг боссон хэмээх хоёр зүйлийн ял тулгаж бүх бурууг Аюушид хүлээлгэхийг хичээжээ. Ийнхүү Аюушийг өдөр бүр занчин элдвээр зовоож байгааг харсан цэргүүд уурсан түүнийг суллан тавихыг шаардаж босохоор завдахад цэргүүдийг аргацаан зогсоож боссон ардуудын хэрэг хэдүй зөв боловч Засаг ноёнтонгоо заалдах эрхгүй гэж буруутган бослогод оролцсон тайж хамжлага нарыг тус бүр хоёр есөн мал, сум эрийг 15 лан түшмэдийг хэд хэдэн есөн малаар торгож шийтгэжээ. Уул шүүх хуралд оролцсон Самбуу хэмээгч тухайн үед Дамбийжанцанд бичсэн нэгэн захидалдаа өгүүлснээр бол 44 зүйл заргын 20-иод нь Манибазарыг буруутгах үндэслэлгүй боловч бусад зүйл нь харьяат засаг *"зоримог зүйгүй ардыг хохируулан хорсголыг үйлджээ"* (ҮТА. М.170-1-613.25) *"үүнээс урагш сайны сургаалыг олж даган явцгаасугай"* (Мөн тэнд) хэмээн сануулснаар Аюуш нарын заргыг төгсгөл болгосон байна. Самбуугийн бичсэн зүйлд дурдсанаар бол Аюушийн заргыг арваад хоног шүүсэн бололтой.

Гэвч ардууд энэ шийдвэрийг огтхон ч хүлээн зөвшөөрөөгүй учир дахин хянан үзэхийг шаардахын сацуу Аюуш тэргүүтэй нилээд айл 2 жил гаруй хошуунаасаа зайлан өөр газар нутаглаж байгаад тэмцлээ дахин үргэлжлүүлэхээр хошуундаа эргэн ирэхэд нь Гурван Цэнхэрийн амны шүүх хурлын шийдвэрийн дагуу ноогдуулсан торгуулийг нэхэхэд нь Аюуш нар хэрэг дуусаагүй хэмээн эсэргүүцэн торгуулийг төлөөгүй байна.

Үүний улмаас 1915 оны намар Аюуш нарын 30 гаруй хүнийг Улиастайд аваачин эрүүдэн шүүхэд Аюуш: *"энэ хэргийг би тэргүүлэн үйлдсэн гэдгээ мэдүүлж бусад нөхдөө заргаас хөндийрүүлсэн учир түшмэл Ламжав гүн Аюушид... хамгийн харгис эрүү"*

шүүлтийг тулган өөрчлөн мэдүүлэхийг шаардаж” (Цэрэндорж-1959.7) бичжээ. Аюуш мэдүүлгээ өөрчлөөгүй ба түүний тэмцлийг өргөн олон дэмжиж байгаагаас айж болгоомжилсон сайд түшмэд Аюушийг нутагт нь буцаажээ. Аюушийг нутагтаа очсон хойно нь “феодал түшмэлүүд...хорлон алахаар” шийдсэн байна. (Мөн тэнд)

1916 онд Засагт хан аймгийн чуулганы газар өөрийг нь дахин баривчлах гэж байгааг Аюуш мэдээд үүнээс өрсөж өөрийн биеэс тасран унасан махаа авч, Нийслэл Хүрээ орж заргалдахаар хөсгөөр нутгаасаа гарчээ. Тэрбээр Шүүх Яаманд заргаа танилцуулах гэтэл түүнийг эс нэвтрүүлсэнд хэдэн өдрийн дараа хүчээр дайран орж заргын бичгээ өгчээ. Тус яам энэ хэргийг “манай үүгээр таслан барагдуулахад мөчид дутагдалтай байна гэдэг үл ялих шалтгаанаар хариулж харин Аюушийг нэг хиагаар харгалзуулан нутагт нь буцаажээ” (Мөн тэнд 8) Энэ нь Аюушийн тэмцэл өргөн олны дэмжлэгийг хүлээсэн бусад хошуу нутгийн ард түмэнд нөлөөлөх нь зайлшгүй байсан учраас уул тэмцлийг орон нутагт нь дарж унтраахын тулд Шүүх Яам уул хэргийг Улиастайн сайдад дахин шилжүүлжээ. Гэвч эцэстээ эзэнгүй хэрэг болж үлджээ хэмээн тэмдэглэжээ.

Цэрэндорж абугайн энэ товхиц бол Аюушийн тэмцлийг түүх тусгайлан судласан цор ганц бүтээл юм. Уул товхицод дурдсан зарим зүйлийг цаашид нэхэн нягталж тодруулуштай зүйл мэр сэр бий. Жишээлбэл: 1903 онд Аюуш тэргүүтэй хэдэн хүн заргын бичиг зохиосон ба түүнийгээ Засагтхан аймгийн чуулганы газарт хүргэх гэж байхад нь засаг Манибазар тэднийг баривчилсан гэдгийг бичгийн сурвалжаар нотлох.

Дээд байгууллагын шийдвэрээр Засагт хан аймаг, Дөрвөд Баядын зарим ноёд, түшмэдийг 1915 оны намар Улиастайн сайдын яаманд Аюуш тэргүүтэй 30 гаруй хүнийг эрүүдэн шүүхэд Аюуш бүх хэргийг өөрөө тэргүүлэн үйлдсэн хэмээн хүлээж бусад нөхдөө заргаас хөндийрүүлсэн гэж бичсэн нь хир зэрэг үнэмшилтэй вэ? Аюуш сэрүүн тунгалаг ахуйдаа өөрийн хүү, үеэл, хүр дүү нарт хэлж бичүүлсэн дуртгалдаа өгүүлснээр бол түүнтэй хамт шүүгдэж байсан хүмүүс Аюушийн тамлуулсныг хараад айж “амьсаа бодож бид нар хятадын юмнаас авснаас засагтай заргаагүй гэж яамны гаднаас нэгэн дуугаар хашгиралдсанд Аюушийн биеийг асрах хэдэн хүмүүсийн хамтаар орхиод бусад ноён түшмэл Да лам ардууд цөмөөр хамаг хэргийг гагц Аюушид хүлээлгэн буцахад Аюушийн хэлэх нь: Та нар нэгэн удаа салсан чинь болж, миний биеийг авч хоцроод алах гэж байна гэж уйлан” (Феодалтай-1959.8) хоцорсон гэжээ.

Энэ мэтчилэнгээр Аюушийн хөдөлгөөнийг судлахад тун хянуур хандмаар буюу янз бүрийн сурвалж баримтын мэдээг олон талаас нь нягтлууштай зүйл цөөнгүй байгааг түүхчид цаашид анхаарах буй за.

1954 онд хэвлэсэн БНМАУ-ын түүхийг нэмэн засварлаж 1966 онд хэвлүүлэхдээ 1911-1918 онд “ард Аюушийн удирдсан ард олны тэмцэл улам хүчтэй үргэлжилжээ” (БНМАУ-ын 1966.275) хэмээн тун товчхон дурджээ.

Энэ зохиолоос хойш хоёр жилийн дараа монголын хэсэг эрдэмтдийн хамтран бичиж хэвлүүлсэн БНМАУ-ын түүх гурван боть зохиолд акад.Ш.Нацагдоржийн бичсэн хэсэгт ард Аюушийн тухай нилээд дэлгэрэнгүй өгүүлж уг хөдөлгөөн 1903 оноос анх эхэлж Манжийн колоничлол, хятадын шунахай худалдаачдын мөлжлөг, феодалын дарлалын эсрэг тэмцэх болсон хэмээн уг хөдөлгөөн үндсэн зорилгыг тодорхойлсон нь Аюушийн тэмцлийн түүх судлалд гарсан шинэ ахиц болсон юм. Аюушийн хөдөлгөөн 1913 оноос дахин сэргэж, уугуул нутаг уснаасаа дайжин нүүсэн боловч Баруун хязгаарыг илбэн тохинуулах сайд 1913 оны 12 дугаар сард цэрэг илгээж, тэднийг нэн даруй буцааж засаг Манибазарт туслахаар яаравчилж Аюушийн хэрэгт холбогдсон ардуудыг аль үзэгдсэн газарт нь баривчлан авч уул хошуунд нь буцаахыг Засагт хан аймгийн бүх засаг ноёдод

чангалан тушаасан ба дүрвэсэн ардуудыг олж нутагт нь буцаажээ. Гэвч ард олны уур хилэнгээс айж Аюушийг баривчлаагүй байна хэмээн тэмдэглэсэн нь урьд өмнөх судлаачдын бүтээлд огт байгаагүй шинэ зүйл юм. Харин энэ тухай ямар эх сурвалжид тулгуурласнаа зохиогч дурдаагүй бөгөөд үүнийг цаашид улам тодруулбал Аюушийн хөдөлгөөний түүхийг боловсруулахад зохих тус дөхөм болох нь лавтай.

Аюуш нарыг нутагт нь хүчээр буцаан суулгасны дараа Аюуш урьд өмнө нь заалдсан 44 зүйлийн хэргээ нотод баримтлан түүнийгээ улс төрийн хэрэг болгохын тулд Манибазараас *"Богд гэгээнтнийг сохор тангад гэж доромжилсон учрыг нэмэн мэдүүлжээ"* (БНМАУ-ын 1968.581) энэ хэрэг улам хурцадсан учир Монгол Улсын Шүүх Яам яаравчлан түүнийг нэгэн тийш болгон шийдэхийг завдаж 1916 оны хамар Аюуш нарыг Манибазарын хамтаар Нийслэл Хүрээнд дуудсан боловч *"самуун"* ардуудыг олноор нь Хүрээнд ирүүлэхээс болгоомжилж уг хэргийг Улиастайн сайдын газарт түүгээр таслан шийдвэрлэхийг даалгажээ. Энэ дагуу мөн оны 11 дүгээр сард уул хэрэгт холбогдсон бүх хүнийг Улиастайд дуудан аваачиж Аюушид харгис эрүү шүүлт тулгасны улмаас тэрбээр хүндээр өвчилсөн учир хэрэг хэлэлцэхийг түр хойшлуулсан байна. Гэвч Аюуш тэмцлээсээ ухарсангүй 1916 оны өвөл Нийслэл Хүрээнд очиж 1917 он гартал байж Шүүх Яамаар заргаа таслуулахыг оролдсон боловч Шүүх Яам уул хэргийг дахин Улиастайд буцааж хянан нийтлүүлэхээр шийдвэрлэжээ. Аюуш зорьсон хэргээ ингэж үр дүнгүй болсонд нутагтаа буцаж очоод санаа бодол нэгтэй ардуудтайгаа хамтарч Манибазарын эсрэг тэмцлээ үргэлжлүүлсэн боловч *"ямар ч үр дүн олсонгүй өнгөрчээ"*. (БНМАУ-ын 1968.582)

Гэвч *"Аюушийн хөдөлгөөн өөрсдөд нь сургамж болсноор үл барам тус орныг гадаад дотоодын мөлжигчдөөс аврахад чиглэсэн учир Монголын нийт ард түмэнд зохих нөлөөгөө үзүүлсэн юм"* (БНМАУ-ын 1968.583) гэж дүгнэсэн байна.

Дээр дурдсанчлан акад.Ш.Нацагдорж багш энэхүү зохиолд ард Аюушийн тухай бичсэн зүйл нь урьд өмнөх судлаачдынхаас илүү тодорхой бөгөөд шинэ санаа, даацтай дүгнэлт хийснээрээ Аюушийн хөдөлгөөний түүх судлалд том ахиц болсон юм.

Харин Ш.Нацагдорж багш 1941 онд өөрийнхөө бүтээлд тэмдэглэсэн зарим зүйлийг энэ зохиолдоо ашиглаагүй байгаа нь сонирхол татдаг. Жишээлбэл, Аюушийн хөдөлгөөнийг Манж Хятадын захиргаанаас зэвсэг бүхий зуун морьт цэрэг Цэцэг нуур луу илгээж дарсан гэж 1941 онд бичсэн зүйл бол тун сонин мэдээ атал үүнийгээ яагаад дараа дараагийнхаа бүтээлд тусгаагүй нь чухам ямар учиртайг өнөөгийн судлаачид нягтлан үзүүштэй.

Академич Б.Ширэндэв 1969, 1999 онд хэвлүүлсэн бүтээлдээ Аюушийн хөдөлгөөнийг хоёр үечилж эхний үе нь 1903-1912 онд хоёрдугаар үе нь 1912-1918 оныг хамарсан хэмээн тэмдэглэжээ. Аюушийн хөдөлгөөний гол ач холбогдол нь юунд орших вэ гэвэл *"ард олны тэмцлийн зорилгыг амжилттай биелүүлэхийн тулд улс төрийн байгууллага байгуулах явдал мөн гэдгийг... харуулж өгсөнд оршино"* (Ширэндэв-1999-74) гэж дүгнэсэн ба Аюушийн 44 зүйл заргаас зөвхөн 9-ийг нь үнэн зөв хэмээн тухайн үеийн шүүх шийдвэрлэсэн гэжээ. Гэхдээ үүнийгээ нотлосон сурвалжийг уул зохиолд тэмдэглээгүй нь харамсалтай.

Аюушийн тэмцлийн тухай өгүүлсэн бас нэгэн хамтын бүтээл бол Монгол-Зөвлөлтийн түүхчдийн хамтран бичиж 1984 онд хэвлүүлсэн БНМАУ-ын түүх нэг боть зохиол юм. Тус зохиолд *"XX зууны эхээр Ар Монголын хэд хэдэн газар ардын эрх чөлөөний хөдөлгөөн өрнөж байсны дотор их нэрд гарсан нь ард Аюушийн удирдсан ардын бослого, Их Хүрээ, Ховдын хязгаарт гарсан үймээн болно"* (БНМАУ-ын - 1985.272) гэж тэмдэглээд 1968 онд БНМАУ-ын Түүхийн дэд ботид бичсэн зүйлийг

хураангуйлан өгүүлсний гадна *“Аюуш, мөн түүнтэй хамт зүтгэгсэд”* 1921 оны *“Монгол ардын хувьсгалд идэвхийлэн зүтгэж, ардын шинэ ардчилсан Монгол Улсыг байгуулахад идэвхтэй оролцож яваад Аюуш 1939 онд нас барсан”* хэмээн Аюушийн тухай судалгааг тодруулсан байна.

Монголын түүхчдийн хамтран туурвиж 2003 онд хэвлүүлсэн *“Монгол улсын түүх”* зохиолд Аюушийн тэмцлийн тухай бичихдээ БНМАУ-ын түүхийн өмнөх ботиудад дурдсан зүйлийг товчлон дурдаад 1959 онд Цэрэндорж абугайн зохиолд бичсэн зүйлийг хураангуйлан нэмжээ. Тухайлбал 1903 онд эхэлсэн уул хөдөлгөөнд оролцогчид засаг ноёнтонгоо заргалдсан өргөдлийг Аюуш тэргүүтэй 12 хүнээр Засагт хан аймгийн чуулган даргын газар хүргүүлэхээр бэлтгэж байгааг Манибазар мэдэж уул хүмүүсийг баривчлахад тэрхүү тэмцэлд оролцсон зарим тайж нар няцаж засаг ноёнтонгоо тэмцэхгүй гэж ам тангараг өгсөн ба *“манжийн захиргаа Аюушийг нөхдийн хамт баривчилж эрүү шүүлт тулган хүн тус бүрийг таван толгой малаар торгожээ”* (Монгол-2003-.262) хэмээн өгүүлжээ.

Гэвч өмнөх судлаачдын бичсэн бүтээлд Аюушийн хөдөлгөөний тухай нилээд чамбай өгүүлсэн зүйлийг ер ашиглаагүй байна. Үүнээс гадна 1903 онд эхэлсэн Аюушийн хөдөлгөөн 1911 оноос хойш чухам хэрхсэн талаар огт дурдаагүй юм.

Өмнө тэмдэглэсэнчлэн Аюушийн тэмцэл хөдөлгөөний түүхийг манай түүхчдээс хамгийн анх сөхсөн акад. Ш.Нацагдорж багш энэ талын судалгаагаа 1978 онд хэвлүүлсэн нэгэн сэдэвт том бүтээлдээ улам лавшруулан авч үзээд хэд хэдэн шинэ дүгнэлт хийсэн юм. Тэрбээр Аюушийн тэмцэл өрнөсөн Манибазарын хошуу нь Монголын бусад нутгийг бодвол капиталист маягийн харилцааны эх үүсвэр эрчимтэй явагдаж байсан юм. Ялангуяа гүн Манибазар бол таваар-мөнгөний харилцаа ихээхэн хөгжиж байсан нөхцөлд өөрийн мөлжлөгөө улам ширүүсгэж *“тэр үеийн зарим том феодалуудын аж ахуйн адилаар аажмаар капиталист шинжийг олж байсан чухамхүү тийм хошуунд ард Аюушийн хөдөлгөөн гарсан нь тохиолдлын хэрэг бус юм”* (Нацагдорж-1978.334) гэжээ. Мөн Аюушийн хөдөлгөөн нь Калпиниковын бичсэнчлэн 1905 онд бус 1903 онд эхэлсэн байх ёстой. Аюушийн хөдөлгөөний хоёрдугаар үе нь бараг найман жилийн дараа 1911 онд эхлээд бараг 1918 он хүртэл үргэлжилжээ. Аюушийн хөдөлгөөний нэгдүгээр үе *“эзэрхэг түрэмгийллийг эсэргүүцэн гаргасан Хятадын И-хэ-туаны цуут бослогын шууд нөлөөгөөр 1900 онд дэгдсэн Улиастайн цэргийн бослогоос хойш гурван жил болоод эхэлсэн бол хоёрдугаар үе нь 11 онд эхэлсэн нь манжийг эсэргүүцсэн нийт Монголын эрх чөлөөний хөдөлгөөнтэй холбоотой”* (Мөн тэнд.334) гэжээ. Акад Ш.Нацагдорж энэ зохиолдоо Аюушийн тухай судлахдаа 1917 онд Шүүх Яаманд өргөсөн 44 зүйлийн зарга бичгийг хожим Аюуш өөрийн хүү болон бусад хүмүүст хэлж бичүүлсэнтэй сайтар тулган нягталж үзсэн байна. Мөн түүнчлэн Аюуш 44 зүйлтэй заргын бичиг үйлдэхдээ олон жил тэмцэл хөдөлгөөнд оролцсон Гижээ хэмээх өвгөнийг зорин хэд хоног явж очин уулзаж зөвлөлгөө авч зохиосон бичгээ найруулгын хувьд засуулж авсныг шинээр тодруулжээ (Нацагдорж 1978 336.344). На багш бээр Аюушийн тэмцэл хөдөлгөөний тухай бичихдээ түүний захирсан засаг Манибазарын дарлан мөлждөг арга цаг хугацаа улирах тутам хэрхэн хувирч өөрчлөгдсөнийг хөөн тодруулсаны сацуу Халхын дорнод хязгаарын засаг Тогтохтөр хэмээх То вантай жишин үзээд То ван бол өөрийн аж ахуйг хөгжүүлэхэд бус харин харьяат ардын аж ахуйгаас бүтээгдэхүүний татвар авахыг онц анхаарч байсан бол Манибазар өөрийн аж ахуйг хөгжүүлэх тухайлбал мал сүргээ өсгөж түүнийгээ худалдааны татварын аж ахуй болгох талыг онцлон анхаарч байсан бөгөөд энэ нь феодализмын задралын үеийн помещик аж ахуйн шинж төрхийг санагдуулмаар болж байжээ хэмээн дүгнэсэн байна.

Манай түүх бичлэгт Аюушийн хөдөлгөөний тухай анх 1941 онд Ш.Нацагдорж багшийн зохиолд хөндсөнөөс эхлээд 1955-аас 2003 онд хэвлүүлсэн Монгол Улсын албан ёсны түүх болон судлаачдын бүтээлд хэрхэн авч үзсэнийг хураангуй өгүүлэхэд ийм буюу. Жич: өөр хэд хэдэн түүхчдийн бүтээл, сурах бичигт Аюушийн тухай бичсэн байх боловч шинэлэг зүйлс хомс бөгөөд өмнөх нь ном, өгүүллээс хуулбарлан авсан нь илэрхий тул тэдгээрийн тухай энд өгүүлэхээс зайлсхийснээ тэмдэглэе.

Аюушийн тэмцэл хөдөлгөөний түүх судлалаар цаашид анзаарууштай зарим зүйл байгааг зориуд тэмдэглэх нь зүйтэй байна. Үүнд: 1. Аюушийн намтрыг тусгайлан судлах, 2. Аюушийн зарга тэмцэл хөдөлгөөнтэй холбогдох баримт сурвалжийг архивуудын сан хөмрөгөөс олж хэвлүүлэн судалгааны эргэлтэд оруулах, 3. Монголын болон гадаадын түүхчдээс Аюушийн тухай хэрхэн авч үзсэнийг зориуд судлаж танилцах нь чухал байна. Үүнтэй холбогдуулан хэлэхэд А.Каллиников, Б.З.Шумяцкий нарын бүтээлд Аюушийн тухай тэмдэглэсэн зүйл байдгийг эрж цуглуулан түүхийн мэргэжлийн сэтгүүлд нийтэлбэл Аюуш судлалд зохих тус дөхөм болох нь мэдээж билээ. 4. Ямар ч судалгаанд тоон үзүүлэлт, статистикийн сурвалжийг нухацтай ашиглавал итгэл үнэмшилтэй гаргалгаа дүгнэлт хийх боломж бүрддэг. Харин сурвалжид буй тоон мэдээнд хайнга хандвал ташаа таамаглал, буруу зөрүү гаргалгаа хийхэд хүргэдэг билээ. Иймээс эрдэмтэн Ц.Пунцагноров абугайн бичсэнчлэн А.Аюушийн тэмцэл хөдөлгөөнд 165 хүн оролцож заргын бичигт нь цөмөөрөө гарын үсэг зурсан уу? Эсвэл түүхч Г.Цэрэндорж абугайн бүтээлдээ дурдсанчлан хятад пүүсийн эзэнгүй орхисон эд хөрөнгийг 165 хүн хувааж авцгаасан уу нэг бол энэхүү хоёр үйл явдлын аль алинд нь тус бүр яг ижил тоотой 165 хүн оролцсон уу гэдгийг үл ялих зүйл хэмээхгүйгээр нэхэн магадлууштай.

Resume

Some resources that directly relevant to the study of Ayush.A, a distinguished hero of western area of Khalkh Mongol, are discussed in this writing.

Ном зүй

1. **БНМАУ-ын** -1955 - БНМАУ-ын түүх. УБ. 1955
2. **БНМАУ-ын** - 1966 - БНМАУ-ын түүх. *Засварлаж нэмсэн хоёр дахь хэвлэл* УБ. 1966
3. **БНМАУ-ын** - 1968- БНМАУ-ын түүх. *Гурван боть. Дэд боть 1604-1917* УБ. 1968
4. **БНМАУ-ын** - 1985- БНМАУ-ын түүх. *Нэмж засварласан гуравдахь хэвлэл* УБ. 1985
5. **Майский И.** – 2001 – Майский И. Орчин үеийн монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр) УБ. 2001
6. **Монгол** – 2003- Монгол Улсын түүх. Дөтгөөр боть (XVII-XX зууны эхэн) УБ. 2003
7. **Монголын** – 1982- Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө тэмцэл. *Баримт бичгийн эмтхгэл* (1900-1914) Эмхтгэсэн А.Очир, Г.Пүрэвээ. УБ. 1982
8. **Нацагдорж** – 1941 – Нацагдорж Ш. Халх дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ба феодалыг эсэргүүцсэн хөдөлгөөнүүд УБ. 1941
9. **Нацагдорж** – 1978 – Нацагдорж Ш. Монголын феодализмын үндсэн замнал (*Түүхэн найруулал*) УБ. 1978
10. **Пунцагноров** – 1955- Пунцагноров Ц.Монголын автономит үеийн түүх УБ.1955
11. **СИЭ** – 1961 – Советская историческая энциклопедия Т.1.М.1961
12. **УТА** – Үндэсний төв архив
13. **Феодалтай** – 1959 – Феодалтай тэмцэж явсан Аюушийн түүх УБ. 1959
14. **Цэрэндорж** – 1959 – Цэрэндорж Засагтхан аймгийн Дархан гүний хушуунд гарсан ардын хөдөлгөөний толгойлогч ард Аюуш УБ. 1959
15. **Ширэндэв** – 2003 – Ширэндэв Б. Монгол Ардын хувьсгалын түүх. Залруулсан хоёр дахь удаагийн хэвлэл УБ. 1999